



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/334

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “д”, Сангийн сайдын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн 282 дугаар журмын 3.2 дахь заалт, 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлэх төрийн байгууллагуудын барилгын их засварыг барилгын чанар, насжилттай нь холбон төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай .

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Т.Норовринчин – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн барилга, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Ч.Сарайдамба – Мэргэжлийн хяналтын газрын Барилгын хяналтын улсын байцаагч

Н.Мөнхбаатар – Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

М.Мөнхбат – Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга О.Эрдэнэ-Оюун - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлэх төрийн байгууллагуудын барилгын их засварыг барилгын чанар, насжилттай нь холбон төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн


• 621010851

2.

зөвлөмж, дүгнэлт гаргах” ажлын хэсгийн тайланг 06 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3. Тус ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Хөдөө аж ахуй, дэд бүтэц хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

The image shows a handwritten signature in black ink over a rectangular official stamp. The stamp contains some illegible text and a central emblem. To the left of the stamp is the word 'ДАРГА' and to the right is the name 'Д.МӨНХСАЙХАН'.